

МОНГОЛЫН “ГЕРМАН СУДЛАЛ” ТӨВ БАЙГУУЛАГДЛАА

Ц.Лхам

Монголын “Герман Судлал” Төвийг эрдэмтэн, судлаач нар болон олон нийтийн санаачилгаар 2002 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн дэргэд үүсгэн байгууллаа. Тус төвийн зорилго нь Монгол Улсад Герман судлалыг бүх талаар дэмжиж хөгжүүлэх, Германы нийгэм эдийн засгийн хөгжил, дэвшил, шинжлэх ухаан, соёл, боловсролын салбар дахь тэргүүний ололт амжилтыг өргөнөөр сурталчлан таниулахад тус дөхөм үзүүлэхэд оршино.

Энэ зорилгодоо хүрэхийн тулд Төв нь судалгаа, мэдээллийн чанартай “ГЕРМАН: Судалгаа, мэдээлэл” сэтгүүлийг хэвлэн нийтлүүлж, нийтийн хүртээл болгоно. Мөн тодорхой сэдэв, төслөөр дагнасан ба хамтарсан судалгаа хийх, судалгааны бүтээл туурвих, орчуулах, хэвлэн нийтлэх ажлыг төвлөрүүлж зохицуулна.

Төв нь түүний зорилго, үйл ажиллагааг дэмждэг хэн бүхэнд гишүүнээр элсэн ороход нээлттэй байна. Тус төв нь өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд, үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу дотоод, гадаадын байгууллага, хувь хүмүүстэй ажил хэргийн холбоо тогтоож хамтран ажиллах, олон улсын төрөл бүрийн хурал, симпозиум, уулзалт, семинар зэрэг арга хэмжээнд идэвхтэй оролцож, мөн тийм арга хэмжээг зохион байгуулна.

Төвийн үйл ажиллагаа нь Монгол, Германы ард түмэн, олон нийтийн хооронд нөхөрсөг хэлхээ холбоо, тал бүрийн хамтын ажиллагааг бүхий л талаар дэмжин хөгжүүлэх улмаар улс орноо Герман ертөнцөд сурталчлан танилцуулах үйлсэд бүрэн чиглэгдэх юм.

Уг төвийн гишүүд болон дотоод, гадаадын талархан дэмжигч, ивээн тэтгэгч байгууллага, хамт олон, хувь хүмүүсээс оруулах хандив, судалгаа, сурталчилгааны бүтээл, хэвлэл нийтлэл, урлаг соёлын арга хэмжээ болон бусад үйлчилгээнээс орох орлого зэргээс Төвийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдэнэ.

Төвийн эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байх бөгөөд түүнээс сонгосон 11 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах

Зөвлөл нь Төвийн өдөр тутмын үйл хэргийг хариуцан явуулна. Уг Төвийг үүсгэн байгуулагчдын хурлаар Төвийн Дүрмийг баталж, Удирдах Зөвлөлийг сонгосон юм.

Удирдах Зөвлөлийн Тэргүүнээр:

Санхүү, эдийн засгийн дэд сайд, доктор, проф. Л. Энхтайван

Дэд тэргүүнээр:

Удирдлагын Академийн дэд захирал, доктор (PhD), проф. Ш. Батсүх

ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн захирал, доктор, проф. Л. Хайсандай

Гүйцэтгэх захирлаар:

МУИС-ийн зочин профессор, доктор, проф. Удо Б. Баркман

Гишүүдээр:

ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич Т. Галбаатар

Зохиолч Чинагийн Галсан

ГХЯ-ны Европ-Араб-Африкийн газрын захирал, дипломатч Л. Удвал

ХБНГУ-д элчин сайд асан, эдийн засгийн ухааны доктор (PhD)

Р.Жамц

МУИС, Олон Улсын Харилцааны Сургуулийн багш, доктор (PhD)

Д.Уламбаяр

ШУТИС-ийн Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн багш, доктор (PhD)

А.Саруул

БХЯ-ны Стратеги судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан О. Машбат

нарыг тус тус сонголоо.